

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ОРЧНЫ ОЙРЫН ХҮРЭЭЛЭЛ БА БНХАУ

*Н.Ариунгуа**

Монгол Улсын хөгжлийн стратегийн тэргүүний зорилтын нэг бол гадаад орчны таатай нөхцлийг бүрдүүлэх замаар улс орны аюулгүй байдлыг хангахад оршдог. Чингэхдээ гадаад бодлогын тэнцвэртэй байдлыг хангах нь манай орны оршин тогтнох нөхцөл, үндэсний аюулгүй байдлыг баталгаажуулах гол үндэс болно. Манай орны гадаад орчны хамгийн ойрын хүрээлэл бол хөрш хоёр орон бөгөөд түүн дотроо БНХАУ нь Монгол Улсын гадаад улс төрийн бодлогод чухал байр эзэлсээр ирсэн билээ. БНХАУ нь Монгол Улстай хөрш зэргэлдээ оршдогийн хувьд аюулгүй байдлын маш чухал гадаад хүчин зүйлийн нэг мөн. Иймээс Монгол Улс өөрийн гадаад бодлогын үндсэн чиглэлээ тодорхойлохдоо БНХАУ-тай харилцах харилцаагаа гадаад бодлогын тэргүүлэх чиглэл хэмээсэн болно. Учир нь Монгол Улс нь Хятадтай хөрш зэргэлдээ орны хувьд түүний геополитик, эдийн засгийн эрх ашгийн хүрээлэлд багтдаг. Иймээс БНХАУ-ын геостратегийн бодлогод Монгол Улс ямар байр суурь эзэлж буй болон цаашид эзлэх байр суурийн талаар судалгаа хийх нь Монгол Улсын цаашдын хөгжлийн стратегийн хэрэгжилт, болон гадаад аюулгүй байдлаа хангахад чухал ач холбогдолтой юм. Нөгөөтэйгүүр бид Монголын талаар баримталж буй БНХАУ-ын геостратегийн бодлого, цаашдын чиг хандлагыг судлахдаа юуны түрүүнд олон улсын хөгжлийн чиг хандлага, Монгол Улстай хил залгаа болон гурав дахь хөрш болох орнуудын тус бүс нутагт эзэлж буй байр суурь, тэдгээрийн явуулж буй бодлогын хүрээнд харьцуулан авч үзэх нь судалгааны арга барилын хувьд оновчтой юм.

Юуны түрүүнд бид Монгол Улсын гадаад хүрээлэлд гарч буй өнөөгийн өөрчлөлтийн нөхцөлд Монголын талаар баримталж буй Хятад улсын гадаад бодлого чухам юунд оршиж байгаа, Хятадын гадаад бодлогын шинэчлэлтэй хэрхэн уялдаж буй талаархи асуудлыг хөндөх нь зүйтэй болов уу. Чингэхдээ Монгол Улсын өөрийнх нь хөгжлийн чиг хандлага дотоод хүчин зүйл, гадаад бодлого дахь өөрчлөлт шинэчлэл нь Хятад улсын байр суурь, бодлогод нөлөөлөх гол хүчин зүйл байх ёстой.

Ийнхүү Монголын гадаад бодлогод нь гарч буй өөрчлөлт нь Монголын гадаад, дотоод хөгжлийн хүчин зүйлээр тайлбарлагдана.

Гадаад хүчин зүйлийн хувьд авч үзвэл, сүүлийн үед манай хоёр хөрш Хятад, ОХУ-тай хил залгаа бүс нутгуудад дэлхийн их гүрнүүдийн геостратегийн сонирхол төвлөрч эхэлж байгаа бөгөөд Монгол Улсад ч мөн хамааралтай болж байна. Энэ нь Ази тив нэлэнхийдээ эрчим хүч эдийн засгийн хөгжлийн асар том хүчин чадалтай бүс болж байгаатай холбоотой. Ийнхүү энэ нутагт олон улсын геополитикийн ашиг сонирхол төвлөрч эхэлж байна. Хятад, Орос улсаас гадна АНУ ч мөн өөрийнхөө нөлөөг алдахгүйн тулд Ази тивд

* Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D), дэд профессор

өсөн нэмэгдэж буй Хятад, Оросын нөлөөг “хазаарлах бодлого” хэрэгжүүлж байна хэмээн шинжээчид үзэж байна. Зарим судлаачдын бичиж байгаагаар “АНУ “New Silk Road” нэртэй нэгэн онцгой глобал программ хэрэгжүүлж Ази тивийн олон орныг түүнчлэн Монголыг түүндээ хамруулж байгаа, 1999 онд АНУ-ын Конгресс хууль батлан Өвөр Кавказ, Төв Ази, Монголд тусалцаа үзүүлэх болсон нь чухамхүү Оростой хил залгаа орнуудыг Америкийн нөлөөний орбит руу татан оруулах санаархал юм”¹ гэжээ.

Сүүлийн үед өргөжин тэлэх хандлагатай байгаа Монгол-Америкийн харилцаа нь хөрш зэргэлдээ орнууд болох БНХАУ, ОХУ-ын анхаарлыг татах нь зүйн хэрэг юм. Энэ талаар Стратегийн судалгааны хүрээлэнгийн шинжээч С.Оюунцэцэгийн үнэлгээг энд дурьдваас “Орос-Хятадын харилцааны агуулга, тэдний хэрэгжүүлж буй харилцан уялдсан бодлого, үйл ажиллагааг анхааралтай ажиглаваас хоёр хөрш маань Америкийг дэлхийн тэргүүлэх гүрэн байхыг хүлээн зөвшөөрөхгүй хийгээд өөрсдийн нөлөөллийн бүс Төв Азид Америкийн нөлөө хэт нэмэгдэх нь тэдний аюулгүй байдлын эрх ашигт үл нийцнэ гэж үздэг нь тодорхой. Тиймээс тэд Америкийн эсрэг хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар хүчин чармайлт тавих нь зайлшгүй. Орос-Хятадын стратегийн түншлэлийн үр дагавар Монгол-Америкийн хөгжиж буй харилцаанд таагүй нөлөөг үзүүлж болзошгүй юм” гэжээ.² Үүнтэй холбоотой ШХАБ-ыг дурдахгүй байж болохгүй бөгөөд чухамхүү энэхүү байгууллагын хүрээнд Америкийн нөлөөг хазаарлах хоёр хөрш орны бодлого явагдах нь мэдээж юм. Үүнтэй уялдуулан дээрхи шинжээч ШХАБ-ын цаашдын хандлага, үйл ажиллагааг тодорхойлох гол хүчин зүйл бол Орос-Хятадын стратегийн түншлэл өнөөгийнх шиг хэр тогтвортой байх вэ? гэдэг асуудал гээд зарим асуудал дээр санал зөрөлддөг ч гэсэн Төв Азийн бүс нутгийг тогтвортой, аюулгүй бүс нутаг болгоход чиглэсэн хоёр улсын ашиг сонирхлын нийцэл удаан хугацаанд энэ бүс нутагт хадгалагдана гэдэг нь ойлгомжтой. Иймд Төв Азийн бүс нутаг болон Монголд бий болсон Америкийн ашиг сонирхлыг хэрхэн сааруулах вэ гэдэг асуудал нь Орос, Хятадыг ШХАБ-д идэвхтэй ажиллах, Төв Азид өөрийн нөлөөллийг бэхжүүлэхэд Туркменистан болон Монголыг хамгийн түрүүнд гишүүнчлэх хэрэгтэй байх бөгөөд энэ нь тэдний сонирхлын давхцлын үр дүн байх болно³ гэжээ.

Сүүлийн арваад жил Монгол-Америкийн харилцаа эрчимтэй хөгжиж АНУ-ын Ерөнхийлөгч Буш манай улсад айчилсан, Монгол Улс Мянганы сорилтын сангаас их хэмжээний мөнгөн тусламж авах болсон, АНУ-аас Монголд ардчиллыг дэмжих зорилгоор 7,5 сая ам.доллар олгох болсон зэрэг нь Монгол дахь Америкийн нөлөө өсөн нэмэгдэж байгаагийн нэг илрэл юм. Энэ нь манай улсын олон тулгуурт гадаад бодлогын зарчимд бүрнээ нийцэж байгаа билээ. Гэвч сүүлийн үед шинжээчид Монгол дахь АНУ-ын нөлөө оролцоог өөр өнцгөөс харж байгааг тэмдэглэх хэрэгтэй. Хэрэв улс төр судлаач М.Батчимэг “үнэн хэрэгтээ улс төрийн сайн харилцаанаас цаашлах АНУ-ын эдийн засгийн бодит оролцоо, ашиг сонирхол гэх юм Монголд бага. Хоёр хөршийн идэвхтэй ажиллагааны

дэргэд Америкийн лоббины ганц нэг төрийн бус байгууллага, хаяахан “үг дайж ирэх “цөөн тооны улс төрчдийн нөлөө жин дарж, анхаарал татах нь багасч байх шиг”⁴ гэж үзэж байгаа бол Оросын улс төрийн конъюктурын судалгааны тэргүүлэх шинжээч Ев.Войко “Оросын Монгол дахь Америкийн сонирхол гэвэл тус улс нь янз бүрийн санхүүгийн “амин зуулгаа” ашиглан ялангуяа албан бус хөтөлбөрийн хүрээнд Америкийн лоббистууд тус орны аж үйлдвэр-түүхий эдийн комплекст нэвтрэх эрхийг олж авсан. Америкийн 100 хувийн болон хувь нийлүүлсэн компаниуд Монголын газрын тос, ашигт малтмал, стратегийн түүхийн эдийн боловсруулалтын салбарт зонхилж байна. Үүгээр үл барам Монгол Улс нь АНУ-ын Афганистан, Иракт хэрэгжүүлж буй энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож байна”⁵ гэж бичжээ. Ямар ч байсан Монголын гадаад орчинд шинэ хүчин зүйл бий болсон нь бодит зүйл бөгөөд Монгол Улсын гурав дахь хөршийн талаар бодлого хэрэгжихэд таатай нөхцөл бүрэлдэж буйг илтгэж байна. Нөгөөтэйгүүр цаашид Монгол-Америкийн харилцааны түвшин нь хоёр хөрш болох БНХАУ, ОХУ-тай харилцаа хэрхэн өрнөхөөс багагүй шалтгаалах нь мэдээж юм.

Монгол Улсын гадаад орчинд бий болсон бас нэг чухал өөрчлөлт бол Монгол дахь Оросын идэвхжилт. Хэдий Хятад, Орос улс Монголыг ШХАБ-ын гишүүн орон болгох зэрэг нэгдмэл зорилт тавьж байгаа боловч хоёр хөрш маань манай орны хувьд өөр өөрийн ашиг сонирхлын үүднээс ханддаг нь нууц биш. Чухамдаа ЗХУ задарч Монгол дахь Оросын нөлөө буурч хоосон орон зай үүссэн тэр үед Хятад улс Монголд өөрийн нөлөөг бий болгож чадсан хэмээн үзэж болно.

Сүүлийн үед Оросын тал Монголыг илүүтэй сонирхох болсон ба дээд хэмжээний хэд хэдэн айлчлал хийгдсэн нь Орос улс, нэгэн цагт Монголд алдсан өөрийн орон зайг эргүүлэн авах сонирхолтой байгааг харуулж байна. Энэхүү байдал манай хөрш Хятад улсын анхаарлыг зүй ёсоор татах нь мэдээж юм. Орос улс сүүлийн үед Монгол руу чиглэсэн идэвхтэй бодлого хэрэгжүүлж байгаа нь газар доорхи баялгыг сонирхохоос гадна геостратегийн хувьд Монголыг алдахгүй гэсэн Оросын гадаад бодлогын чиглэлээр тайлбарлагдана. Орос хятадуудын нэр хүнд Монголын ард нийтийн дунд унасан явдлыг ашиглан өөрийн алдсан орон зайг нөхөж авахад таатай нөхцлийг бүрдүүлж байна. Ер нь ОХУ эдийн засгийн хувьд бэхжихийн сацуу дэлхийн хэмжээнд идэвхтэй гадаад улс төрийн бодлого явуулж, өөрийн орон зайгаа тэлэн бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж байгаатай уялдаатай. Орос улс хил залгаа хийгээд удаан жил өөрийн нөлөөнд барьж байсан Монгол Улсыг анхаарлаасаа гаргахгүй гэдэг нь ойлгомжтой. Хэрэв чингэвээс олон зуун жилийн уламжлалтай Монголын талаар явуулж ирсэн Оросын бодлого талаар болж түүний геостратегийн бодлогод гарз учирна гэсэн үг юм. Оросын улс төрийн конъюктурын судалгааны дээр дурьдсан тэргүүлэх шинжээч Ев.Войко Монголын талаархи баримталж буй Оросын өнөөгийн бодлогын талаар ийнхүү бичжээ: “Хэдий Монгол Улс нь ашигт малтмал, байгалийн онцгой их нөөц

баялаг байхгүй боловч томоохон геополитикийн тоглогч болох их гүрнүүдийн хурц өрсөлдөөний бай болоод байна. Өнөөдөр Монгол нь Оросын сонирхлын хүрээлэлд багтаж байгаа боловч Хятад болон АНУ нь Монголыг Ази дахь түрэмгийллийнхээ түшиц газар хэмээн үзэж түүнийг өөрийн хяналтанд оруулахыг чармайж байна. ЗХУ энэ нутгийг орхиж явснаас хойш Өмнөд Солонгос, Япон мөн түүнд санаархаж байгаа билээ. Монголчууд өөрсдөө Оросыг итгэл даах, ашигтай түнш хэмээн үздэг. Нөгөөтэйгүүр Монгол нь Хятадтай хилэлдгийн хувьд Орос улстай нягт харилцаа тогтоосноор хил орчмоороо Оросын хүчин зүйлийг нэмэгдүүлэх юм. Монголын төлөө тэмцлийг Хятадын удирдлага явуулж байгаа бөгөөд Монголтой хийж буй эдийн засгийн хамтын ажиллагаа нь Орос-Монголын хамтын ажиллагаатай харьцуулахад тоон үзүүлэлт, хэмжээгээрээ их юм. Хятадаар дамжин Монголын маш их хэмжээний ачаа тээвэр бусад орон руу чиглэдэг, Хятадын хөрөнгө оруулагчид Монголд маш идэвхтэй ажиллаж байна. Чингэхдээ Оросын бизнесменүүдийг бодвол Хятадын ажил хэрэгч хүмүүс нь улсын, хувийн гэхгүй том, дунд жижиг салбарт аль алинд нь анхаарлаа хандуулдаг”⁶ гэжээ. Үнэхээр сүүлийн жилүүдэд Монголыг тойрсон олон улсын чанартай өрсөлдөөн бий болсон нь дэлхийн хэмжээнд явагдаж буй хүчний шинэ хувиралттай холбоотой. Нөгөөтэйгүүр Ази болон дэлхийн хэмжээнд өсөн нэмэгдэж буй төрөл бүрийн ашигт малтмал болон эрчим хүчний эх үүсвэрийн эрэлт хэрэгцээ гадны томоохон хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж байгаа өнөө үед Хятадын аварга том зах зээлийн хажууд орших Монгол орон байгалийн их нөөцөө ашиглаж эхэлсэнтэй холбоотой. Ийнхүү зөвхөн геополитикийн хувьд их гүрнүүдийн анхааралд байсан Монгол нь гадаадынхны эдийн засгийн ашиг сонирхлыг төрүүлэх болсон юм. Чингэхдээ хоёр хөршийн болон зарим гуравдагч орнуудын манай улсын талаар явуулж буй бодлогын хувьд гэвэл зөвхөн эдийн засгийн ашиг сонирхлоос үүдэн гарч буй биш энэхүү сонирхол нь илүү өргөн утгатай нь мэдээж юм. Юуны түрүүнд энэ нь хоёр хөршийн бодлогод эдийн засаг, улс төр, геополитикийн сонирхол багтаж тэдний гео-эдийн засгийн ашиг сонирхол манай оронд төвлөрч ирж байгааг илтгэж байна. Орос улс сүүлийн үед өнгөрсөн үе ялангуяа XX зууны үеийн түүхийг зарим орнууд “засварлах” гэсэн оролдлого хийж буйг буруушааж байгаа бөгөөд хөрш зэргэлдээ орнуудтай тогтоож буй харилцаагаа дайсны эсрэг хамтран тэмцэж явсан өнгөрсөн үеийн түүхэн дурсамж, үзүүлж байсан эдийн засгийн тусламж зэргийг иш үндэс болгон хоёр орны харилцааг түүхэн талаас нь үндэслэн “харилцааны уламжлал” хэмээх хүчин зүйлийг бий болгох бодлого баримталж байгаа тал ажиглагдаж байна.

Ийнхүү Монголын гадаад орчинд гарсан шинэ нөхцөл байдалд Монголын талаархи БНХАУ-ын бодлогод өөрчлөлт гарах уу гэсэн асуулт нээлттэй байгаа юм.

Ер нь Хятад улс манай орныг хил залгаа улсын хувьд өөрийн хойд хилийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл хэмээн үздэг. Иймээс ч БНХАУ Монгол Улсыг Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад

оруулах сонирхолтой байдгийг нэгэнт дээр дурьдсан билээ. Үгүй гэхэд Монголын эвсэлд үл нэгдэх хөдөлгөөнийг дэмжих тал мөн ажиглагддаг. Тухайлбал Хятадын эрдэмтэд Монголын стратегийн ач холбогдлыг ийнхүү дүгнэн бичсэн байхыг дурьдваас “ЗХУ нь ХХ зууны 60-80-аад оны хугацаанд Хятадыг барьж байх глацдарм болгон Монголыг ашиглаж байв. Харин ЗХУ задарч Оросын цэрэг Монголыг орхиж гарснаас хойш АНУ, Япон улс тэрхүү чөлөө завьг ашиглан Орос, Хятадын хооронд орших энэхүү онцгой бүсийг өөрийн анхааралд авсан юм. Ялангуяа АНУ тэнд эдийн засаг, улс төр, оюун санаа, соёл, цэргийн хүрээнд нэвтрэн орох оролдлого хийж байгаа нь Зүүн хойт Азид өөрийн эрх ашгийн хүрээг тэлж хожмын өдөр Хятад, Орос улсуудад нөлөөлөх зорилго агуулж байгаа юм”⁷ хэмээжээ. Цааш нь Хятадын эрдэмтэд геополитикийн үүднээс Монголын талаар баримтлах Хятадын байр суурийг ийнхүү тодорхойлсон байх нь: “түүхэн хийгээд орчин үеийн үүднээс харахад Монгол Улс нь геополитикийн хувьд маш чухал байршилтай учир зарим нэгэн орнуудын зүгээс түүнийг Хятадын эсрэг түшиц газар болгох гэсэн оролдлогыг сэрэмжлэн зогсоож, эвсэлд үл нэгдэх байр суурийг нь хангах замаар Монголын байр суурийг нь Хятадын стратегийн үндсэн зорилтод нийцүүлэх шаардлагатай”⁸ хэмээн бичжээ. Нөгөөтэйгүүр Монголын геостратегийн байр суурийг тайлбарлахдаа “гурав дахь хөрш хэмээх” үзэл баримтлал нь хөгжингүй орнуудаас улс төр, эдийн засгийн тусламж авахаас гадна их гүрний хүчээр өөрийн тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байгаа хэмээн үзжээ. Оросын сонирхолын хувьд гэвэл Монгол нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь Оросын чухал түшиц газар бөгөөд Уралын хүнд үйлдвэр хийгээд Сибирийн төмөр замтай холбоотойгоороо Оросын Алс Дорнодын стратегийн Өмнөд хэсгийн халхавч мөн юм. Нөгөөтэйгүүр Орос, Монгол дахь Америкийн нөлөө ихэсч буй хандлага, мөн өдөр ирэх тусам нэмэгдэж буй Хятадын нөлөөг харгалзан Монголтой харилцаагаа сайжруулахад хүрч байгаа, мөн түүнчлэн Монголын түүхийн эд ялангуяа стратегийн чанартай ураны нөөцөд санаархаж байгаа гэжээ. Цааш нь Америкийн цэргийн нэвтрэлт болон Орос-Монголын харилцаа сэргэсэн явдал тус орны төлөө өрсөлдөх их гүрнүүдийн сонирхол нэгэнт бий болсныг илтгэж байна. Ялангуяа АНУ цэрэг дайны талаар Монголтой харьцах болсон нь Хятадын хойд бүс нутгийн хилийн аюулгүй, тогтвортой байдалд далд аюул учруулж байна гэжээ. Ийнхүү Хятадын шинжээчид Монголын стратегийн ач холбогдол, гадаад орчинд нь ийнхүү үнэлэлт дүгнэлт хийсэн байна.

Дээрхи зүйлээс харахад Монгол Улс нь БНХАУ-ын хувьд эдийн засаг нь хөгжөөгүй хоцрогдсон ядуу буурай орон байхаасаа илүү стратегийн маш чухал байрлалд орших, мөн эрдэс баялгаар чамалхааргүй их баялагтай орон юм. Иймээс цаашид Хятад чухамхүү энэ үүднээс Монголд хандах бөгөөд юуны түрүүнд Монголтой эдийн засгийн харилцаагаа улам хөгжүүлэх, тулгарч буй асуудлыг аль болохоор шийдвэрлэх байр сууринаас хандах болов уу. Учир нь эдийн засгийн хөшүүрэг бол Монгол дахь Хятадын

нөлөөг ихэсгэн бататгах чухал хүчин зүйл юм. Энэ нь цэвэр эдийн засгийн хувьд ч Хятад улсад ашигтай бөгөөд Монголын уул уурхайн салбарт хөрөнгө оруулах сонирхолтой нь яв цав нийцэж байгаа болно. Энэ нь мөн манай улсын эрх ашигт бүрэн нийцэж байгаа бөгөөд геополитикийн хувьд дундыг баримтлах бодлогоо хэрэгжүүлэх замаар аюулгүй байдлаа хангах, өөрийн эдийн засгаа хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт нөгөө талаас Хятадын асар том зах зээл дээр дулдуйдан гадаадын бусад орны хөрөнгө оруулалтыг татах зэрэг юм. Нөгөөтэйгүүр Хятад улс нь хөгжлийн асар их хурдацтай хөгжиж байгаа болон ирээдүйд түүний хөгжлийн прогноз сайн байгаа зэрэг нь хөрш зэргэлдээ манай орны хувьд эдийн засгийн маш ашигтай нөхцлийг бүрдүүлж байгаа юм. Дээрх бодлого нь Хятадын шинэ гадаад бодлогын зарчимд ч нийцэж байгаа. Хятад улс хөрш орнуудтайгаа найрамдал, сайн хөршийн харилцаа тогтоох нь Хятад улсын хувьд энх тайвнаар хөгжих чухал баталгаа хэмээн албан ёсоор тунхагласан бөгөөд үүнийг ХКН-ын XXV их хурлаас дэвшүүлсэн гадаад бодлого, хөгжлийн шинэ стратегидаа дахин нотолсон болно. Хятад улс хөрш орнуудынхаа талаар баримтлах бодлого, байр сууриа “элэгсэг, аюулгүй, баян чинээлэг хөршүүд байх” болон “хөрштэйгөө түншийн сайн харилцаатай байх”-д оршино гэж тодорхойлж байгаа юм.

Чухамхүү энэхүү бодлого нь бүр 90-ээд оны үед хэрэгжиж ирсэн бөгөөд 1994 онд хоёр орны хооронд байгуулагдсан “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” үүний нэг тод илрэл юм. Дээрхи зарчмын дагуу хоёр орны харилцаа ерөнхийдээ хөгжиж байгаа ба цаашид ч хөгжих бүрэн үндэслэлтэй.

Нөгөөтэйгүүр манай гадаад бодлогын гол үндэс болох “хоёр хөрштэй харилцах харилцаагаа тэргүүлэх чиглэл” хэмээн тодорхойлсон болон “гуравдагч хөрш” мөн “эвсэлд үл нэгдэх” байр суурийн тухай үзэл баримтлал нь маш зөв сонголт байсныг өнөөгийн нөхцөл байдал нотлон харуулж байгааг тэмдэглэх хэрэгтэй юм.

Хоёр хөрш маань олон улсын хэмжээнд бодлого тодорхойлогч, цэрэг, улс төр, эдийн засгийн хувьд их гүрнүүд бөгөөд энэ нь их гүрнүүдийн хөгжлийн нөлөө Монголд тодорхой хэмжээгээр тусах нь манай улсын хувьд тааламжтай зүйл. Орос-Хятадын харилцаа стратегийн түншлэлийн түвшинд хүрсэн өнөө үед манай улс хоёр хөршийн эдийн засгийн хамтын ажиллагаанд аль болохоор өөрт ашигтай оролцох, мөн тус хоёр орны бусад улс гүрнүүдтэй байгуулах олон улсын төсөлд өөрийн бололцоогоор оролцох, харилцан ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх нь Монгол Улсын эрх ашигт зүй ёсоор нийцэх билээ. Нөгөөтэйгүүр хоёр хөршийн ашиг сонирхол Монголд төвлөрч байгаа явдал нь тэдгээрийн хооронд өрсөлдөөнийг бий болгох бөгөөд үүнд манай улс үндэснийхээ эрх ашгийн үүднээс маш ухаалаг, хянуур хандах нь зүйтэй юм.

Ер нь монголчууд түүхэндээ хоёр хөрштэйгээ харилцах хангалттай туршлагатай ард түмэн бөгөөд түүхийн урт хугацаанд өөрийн ашиг сонирхлыг боломжийн хэрээр хамгаалсаар ирсэн билээ.

Нөгөөтэйгүүр манай эвсэлд үл нэгдэх байр суурь нь манай улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлын гол үндэс бөгөөд энэхүү бодлогоо хэрэгжүүлэхдээ гадаад эдийн засгийхаа тэнцвэртэй байдлыг дээрхи бодлоготойгоо маш нарийн уялдуулах нь зүйтэй болов уу. Чухамхүү энэ нь хөрш Хятад улстай харилцах гол зарчим байх ёстой. Нөгөөтэйгүүр манай улс хөгжлийнхөө шинэ шатанд гарч, эдийн засгийн ардчилал, үйлдвэржих үйл явц эхэлж буй өнөө үед Хятадтай харилцах харилцаагаа урьдынхаас илүү үр дүнтэй, харилцан ашигтай байх үндэс суурин дээр хөгжүүлж хоёр орны харилцааг мөн шинэ шатанд гаргах шаардлагатай байна.

Эцэст нь хэлэхэд Хятадын гадаад бодлогод гарч буй үзэл баримтлалын шинжтэй шинэ зүйлүүдийг манай улс нарийвчлан судалж тэдгээрийг гадаад бодлогодоо тооцоолох шаардлагатай юм. Өнөө Хятад улс нь “Энх тайвнаар хүчирхэг болох” гэсэн геополитикийн шинэ концепцийг хэрэгжүүлж байгаа билээ. Хятадын эрдэмтэд сүүлийн үед мөн “өргөн зах хязгаар” хэмээх концепцийг дэвшүүлж энэхүү концепцийн дагуу зах хязгаар гэдэг ойлголт нь 3 түвшинээс бүрэлдэх бөгөөд нэгдүгээрт Хятадтай хил залгаа бүс нутаг, хоёрт Ази, Номхон далайн бүс нутаг, гуравдугаарт Еврази болон Номхон далай, Энэтхэгийн далайн эргийн орнууд тус тус багтах ажээ. Өөрөөр хэлбэл шууд хил залгаа үгүйгээс үл хамааран Хятадын сонирхол буй бүх орнууд Хятад улсын хөрш оронд тооцогдох ажээ.⁹ Нөгөөтэйгүүр Хятад улс “ард иргэд рүү хандсан дипломат бодлого” гэсэн шинэ нэр томьёо, үзэл баримтлал дэвшүүлжээ. БНХАУ-ын Гадаад Харилцааны сайд Ли Жаосины тэмдэглэснээр энэ нь зөвхөн Хятадын ард түмний эрх ашигт нийцээд зогсохгүй мөн бусад улс үндэстнүүдийн эрх ашигт бүрнээ нийцэх ажээ. Өөрөөр хэлбэл “улсын төлөө дипломат бодлогоос” “ард түмний төлөө дипломат бодлогод” шилжиж байгаа ажээ. Энэхүү бодлого нь хилийн чанадад байгаа Хятад үндэстний эрх ашигт нийцэх хийгээд үндсээрээ бахархах сэтгэлийг нь дэвэргэх, Хятадын эдийн засгийн өндөр технологийн салбарын хөгжлийг түргэсгэх, бусад орнуудтай маргаантай асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болох ач холбогдолтой ажээ.¹⁰ Хятадын гадаад улс төрийн үзэл баримтлалд гарч буй дээрхи хүчин зүйлүүд нь Монголын талаар баримтлах бодлогод мөн тусгалаа олох нь мэдээж юм. Энд тэмдэглэхэд Хятадын улс төр судлаачдын дэвшүүлж буй гадаад улс төрийн “өргөн зах хязгаар” хэмээх үзэл баримтлал нь манай улсын “гуравдагч хөрш” гэсэн үзэл баримтлалтай зарчмын хувьд төстэй. ОХУ-ын гадаад улс төрийн бодлогын зарчимд ч ижил төстэй үзэл баримтлал ажиглагдаж байгааг хэлэх хэрэгтэй бөгөөд дээрхи зүйлүүд нь угтаа дэлхийн глобалчлалын хандлагатай шууд холбоотой. Нөгөөтэйгүүр дээр дурдсан “ард иргэд рүү хандсан дипломат бодлого” гэсэн үзэл баримтлал нь Хятадын гадаад улс төрийн бодлогын агуулга юуны түрүүнд улс гэсэн ойлголтоос хальж хятад үндэстэн гэсэн өргөн цар хүрээтэй болж байгааг харуулж байна. Эдгээр нь цаанаа маш нарийн утга учиртай бөгөөд юуны түрүүнд Хятадын нөлөө глобал шинжтэй болж байгаа нөгөөтэйгүүр Хятад улс хятад үндэстний эрх ашгийг дэлхийн аль ч өнцөгт хамгаална гэсэн үг юм.

Ийнхүү Монгол, Хятад улсын геополитикийн харилцан хамаарал, хоёр орны гадаад хүрээлэлд гарч буй шинэ хүчин зүйл хийгээд манай хоёр орны дотоод хөгжлийн үйл явц, хоорондын харилцаанд оршиж буй зарим нэг тулгамдсан асуудал, тэдгээрийг шийдвэрлэх шаардлага зэрэг нь цаашид хоёр орны харилцаанд өөрчлөлт шинэчлэл авчрах нь зайлшгүй.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. <http://www.prawda.ru/world/asia/far-east/3259993-1/2009.10.2/>
2. С.Оюунцэцэг. Орос-Хятадын стратегийн түншлэл: Монгол Улсын аюулгүй байдал. “Стратеги судлал”, 2/2008, №42, тал 37
3. С.Оюунцэцэг. Дээрхи зохиол.
4. М.Батчимэг. Путиний айлчлал геополитикийн том нүүдэл мөн үү?-Өдрийн сонин 2008.05.08
5. <http://actualcomment.ru/mens/154.html>
6. <http://actualcomment.ru/mens/154.html>
7. Ю Гуйпин, Жань Жэнхуа. Хятад-Монголын геополитикийн хамаарал ба Хятад улсын бодлого- Research on Social Reform in the Developing Countries –Ulaanbaatar International Symposium Anthology. 2004, p.190
8. Ю Гуйпин, Жань Жэнхуа дээр дурдсан зохиол ,т.193
9. CIR. 2005, №2, p.15-16
10. BR62005, №4,p.12